



**НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024. оны 12. дугаар сарын 31.

Дугаар 24.

Налайх

Компанийн удирдлага, зохион байгуулалтын
бүтэц орон тоог шинэчлэн
батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Компанийн дүрмийн 7.3.4, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн а/4157 дугаартай удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Налайхын Дулааны станц” ТӨХК-ийн бүтэц, зохион байгуулалтыг хавсралтад заасны дагуу шинэчлэн баталж, орон тооны дээд хязгаарыг 123 байхаар тогтоосугай.

2. Батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу албан тушаалын жагсаалтыг гарган баталж, энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал (Ц.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.


3. Компанийн бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбогдуулан шинээр нэмэгдэх хоёр орон тооны цалин болон бусад зардлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2025 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгаж, батлуулж ажиллахыг гүйцэтгэх захирал (Ц.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

4. Бүтэц зохион байгуулалтаар шинээр нэмэгдсэн болон өөрчлөлт орсон албан тушаалуудын ажлын байрны тодорхойлолт, холбогдох журмуудыг шинэчлэн баталж, мөрдөж ажиллахыг гүйцэтгэх захирал (Ц.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.


5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай 17 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (Г.Тунгалаг)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ЦЭРЭНЖАМЦ



ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 34 тоот тогтоолын хавсралт

НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН УДИРДАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

